

## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2019 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

|                                |                                                                                                                                                                                                                           |                  |                                                                        |                                                                                                                                          |
|--------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хурлын нэр:                    | МЦХ ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал                                                                                                                                                                     |                  |                                                                        |                                                                                                                                          |
| Огноо:                         | 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр<br>11:00-14:00                                                                                                                                                                         | Уулзалтын газар: | Компанийн хурлын заал                                                  |                                                                                                                                          |
| Хурлын дарга:                  | Чулуунбатын Пүрэвсүрэн, МЦХ ХК-ийн Стратеги төлөвлөлтийн газрын дарга                                                                                                                                                     |                  |                                                                        |                                                                                                                                          |
| Тооллогын комисс:              | Тооллогын комиссын дарга Д.Ганцэцэг, Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн<br>Гишүүд: Б.Ариунгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын ахлах мэргэжилтэн<br>О.Содбаяр, Хүний нөөцийн албаны мэргэжилтэн       |                  |                                                                        |                                                                                                                                          |
| Хурал зохион байгуулах комисс: | Зохион байгуулах комиссын дарга Д.Болдбаатар, МЦХ ХК-ийн Удирдлага, хүний нөөцийн газрын дарга<br>Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br>Ж.Азбаяр, Удирдлага, хүний нөөцийн газрын хуулийн ахлах мэргэжилтэн |                  |                                                                        |                                                                                                                                          |
| Оролцсон хувьцаа эзэмшигчид    | 1.                                                                                                                                                                                                                        | С.Уранчимэг      | Хувьцааны тоо 20 ширхэг                                                | Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276.0 ширхэг. Үүнээс нийт 24,048,640 ширхэг саналын эрх бүхий 22 хувьцаа эзэмшигч оролцсон. |
|                                | 2.                                                                                                                                                                                                                        | Т.Эх-Оюун        | Хувьцааны тоо 81 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 3.                                                                                                                                                                                                                        | Ч.Гансэлэм       | Хувьцааны тоо 882 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 4.                                                                                                                                                                                                                        | М.Алтан-Очир     | Хувьцааны тоо 210 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 5.                                                                                                                                                                                                                        | Ч.Баттөмөр       | Хувьцааны тоо 13 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 6.                                                                                                                                                                                                                        | Х.Аюунзана       | Хувьцааны тоо 40 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 7.                                                                                                                                                                                                                        | Д.Баярсайхан     | Хувьцааны тоо 70 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 8.                                                                                                                                                                                                                        | Ж.Энхтунгалаг    | Хувьцааны тоо 100 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 9.                                                                                                                                                                                                                        | М.Шигшээ         | Хувьцааны тоо 4 ширхэг                                                 |                                                                                                                                          |
|                                | 10.                                                                                                                                                                                                                       | Р.Баасансүрэн    | Хувьцааны тоо 5 ширхэг                                                 |                                                                                                                                          |
|                                | 11.                                                                                                                                                                                                                       | Э.Энхбаяр        | Хувьцааны тоо 3,465 ширхэг                                             |                                                                                                                                          |
|                                | 12.                                                                                                                                                                                                                       | С.Жамбал         | Хувьцааны тоо 210 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 13.                                                                                                                                                                                                                       | Г.Алтан-Оч       | Хувьцааны тоо 200 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 14.                                                                                                                                                                                                                       | Д.Мөнхтөр        | Хувьцааны тоо 88 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 15.                                                                                                                                                                                                                       | Д.Бейбит         | Хувьцааны тоо 542,456 ширхэг                                           |                                                                                                                                          |
|                                | 16.                                                                                                                                                                                                                       | Ч.Маам           | Хувьцааны тоо 70 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 17.                                                                                                                                                                                                                       | Д.Доржсүрэн      | Хувьцааны тоо 245 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 18.                                                                                                                                                                                                                       | А.Дагвадорж      | Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, хувьцааны тоо 24,499,287 ширхэг |                                                                                                                                          |
|                                | 19.                                                                                                                                                                                                                       | Ц.Хуяг           | Хувьцааны тоо 199 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 20.                                                                                                                                                                                                                       | Т.Долгор         | Хувьцааны тоо 25 ширхэг                                                |                                                                                                                                          |
|                                | 21.                                                                                                                                                                                                                       | З.Хаянхярваа     | Хувьцааны тоо 770 ширхэг                                               |                                                                                                                                          |
|                                | 22.                                                                                                                                                                                                                       | М.Отгонбаяр      | Хувьцааны тоо 200 ширхэг                                               |                                                                                                                                          |
| Ирц:                           | 96.82%                                                                                                                                                                                                                    |                  |                                                                        |                                                                                                                                          |

### ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
4. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай
5. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн үндэслэлийг танилцуулах тухай

### СОНССОН нь:

**Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга:** Ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас 24,048,640 ширхэг хувьцаа эзэмшиж буй 22 хувьцаа эзэмшигч ирж 96.82

хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

**Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга:** МЦХ ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.

**М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал:** 2018 оны үйл ажиллагааны үр дүн, 2019 оны зорилтыг танилцуулав.

**Л.Болдбаатар, МЦХ ХК-ийн НББА-ны дарга:** Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулав.

**Ц.Норовжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга:** Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг танилцуулав.

**Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:** Компанийн санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийн тогтоолыг, ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийн төслийг тус тус танилцуулав.

**Ц.Норовжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга:** Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2018 оны компанийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаагүй үндэслэлийг танилцуулав.

**Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга:** Өнөөдрийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлуудын танилцуулгыг хийж дууслаа.

**Асуулт хариулт, санал:**

**Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга:** Хэлэлцсэн асуудлаар тодруулах зүйл, дэвшүүлэх санал байвал хувьцаа эзэмшигчид та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье.

**Д.Баярсайхан, хувьцаа эзэмшигч:** Тайлан мэдээг сонслоо. Хийгдэж байгаа ажил болон цаашид хийгдэх ажлуудын төсөл, прогноз авлаа гэж үзэж байна. 1. Энэ жилдээ яагаад ногдол ашиг өгөх өө болж байгаа вэ гэхээр миний ойлгож байгаагаар технологийн шинэчлэл хийхтэй холбогдуулаад зардал их гарсан үүнтэй холбогдсон болов уу гэж бодож байна. 2. Ирэх жилээс ногдол ашиг хуваарилах санал бодол, хүсэл байна уу? 3. Иргэний хувьд, гэр хорооллоор АТС-ийн шугам явж байгаа. Хуучин иргэний хамгааллын шугамаар ашиглана гэсэн үндэстэй байдаг. АТС-ийн шугам тэр бүр явж байна уу үгүй юу, би сайн мэдэхгүй байна. Айлын хашаан дотор шон байгаа. Шугам ашиглагддаггүй бол тэр шугамыг хурааж цэгцлэх тийм асуудал байна уу, Яагаад гэвэл энэ хаалга үүдээ нааш цааш нь болгох, гадагшаа онгойх уу, дотогшоо онгойх уу зэрэг зохион байгуулалт хийх, хашаан дотроо зай багатай ш дээ эргэлт хийхэд саад учраад байдаг. Энэ үүднээс ийм бодол байгаа юм.

Та бүхний ажилд утасгүй сүлжээ тавигдаж байхад, утастай асуудлаа яаж зохион байгуулах вэ?

**М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал:** Гэр хорооллын дунд агаарын багана байгаа. Манай мэдлийнх ч байгаа, Мэдээлэл холбооны сүлжээ компани, Радио сүлжээний газрын хуучин өргөн нэвтрүүлэг явуулж байсан тэдний ч юмнууд байгаа.

Хаана тийм зүйл байгааг нягтлах хэрэгтэй, орж гарахад түвэгтэй зүйл байгаа бол та түүнийг нь тодруулаад өгвөл манай юм байна уу, эсвэл бусдынх байна уу гэдгийг нь тодруулах хэрэгтэй. Сүүлийн үед агаарын баганууд бүгд нэр хаягтай болсон байгаа. Мэдээлэл холбооны сүлжээ компанийнх бол МХС, манайх МЦХ, Радио сүлжээ бол РТС гэж байгаа.

**Д.Баярсайхан, хувьцаа эзэмшигч:** Чингэлтэй дүүргийг 14 дүгээр хороо л доо.

**М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал:** Манай зүүн бүс хариуцдаг юм байна. Наранцэцэг дарга хариуцаад боломжоороо шилжүүлэх асуудлыг зохицуулъя.

**Н.Наранцэцэг, Зүүн бүсийн холбооны газрын дарга:** За.

**М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал:** Яваандаа агаарын багана байхгүй л болно л доо, тэгэхдээ нэгэнт байгаа хөрөнгийг ашиглавал ямар вэ. Нэгэнт татсан кабель шугам, энэ чинь бас хөрөнгө шүү дээ. Хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, үр дүнтэй ашиглахыг бодно. Яваандаа цаг хугацааны хувьд бүгд утасгүй болохоор утастай шугам хэрэггүй болох байх. Кабел шугамыг үгүй хийх, асуудлыг хөрөнгийн эзэд л мэднэ. Гамшгийн үед, иргэний хамгаалал, нүүлгэн шилжүүлэлтийн үед утасгүй холбоо үгүй болдог, энэ үед утсан холбоо зайлшгүй хэрэгтэй зүйл. - Ашгийн талаар гүйцэтгэх удирдлагын хувиар аль болох ногдол ашиг хуваарилахыг л бодно. Эздийн төлөө ажиллаж байгаа. Мэдээж зайлшгүй нөхцөл байдал байгаа. Энэ онд Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үр өгөөжийг дээшлүүлэх, та бүхэн харж байгаа байх үндсэн үйл ажиллагааны орлого буураад байгаа. Телефон утасны орлого буураад үүнийг орлох бүтээгдэхүүн байхгүй өнөөдрийг хүрсэн. Үүнийг үүрэн, утасгүй холбоо, утасгүй интернэтийн үйлчилгээг авч байж л бид энэ үндсэн үйл ажиллагаад орлоготой болгоно. Компани хоёр хос морьтой гэж ойлгох хэрэгтэй нэг нь үндсэн үйлчилгээний орлогоос өндөр ашиг олж байвал нэн тэргүүнд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах ёстой, нөгөөдөх нь бусад орлого. Энэ жил бүсээ нилээн чангахан татаад, тэвчиж болох бүх зардлаа тэвчиж байж ашигтай ажилласан. Ашигтай байна гэдэг маань энэ компанид эдийн засгийн боломж, нөөц бололцоо байна гэсэн үг. Ямар ч удирдлага зах зээлд эерэг үзүүлэлттэй ажиллах талаар үүрэгтэй учир энэ талаар нилээн ажиллаж байгаа. Үндсэн үйл ажиллагаа сайжруулах гол асуудал нь түрүүний миний ярьсан техник технологийн зөв шийдэл зөв бодлого.

**Д.Бейбит, хувьцаа эзэмшигч:** Санхүүгийн талаар хэдэн тодруулах юм байна. 1. Хуримтлагдсан ашиг яагаад 3.7 тэрбум төгрөгөөр буурсан байдаг билээ? 2. Богино хугацаат өр, төлбөр яагаад нэмэгдээд хасагдахгүй байгаа, тэгээд урт хугацаат өр төлбөр хэвэндээ, ерөөсөө буурахгүй байх юм. Энэ ямар учиртай вэ? 3. Бусад зардал гээд 2, 3 хуваасан байна тэд нар ямар учиртай вэ?

**Л.Болдбаатар, МЦХ ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн албаны дарга:** Хуримтлагдсан ашиг яагаад буурсан бэ гэж асуулаа. Утасгүй холбооны станц 2012 онд татан буугдсан түүнтэй холбоотой бараа материалууд хуримтлагдсан байсныг 2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргуулж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС)-ын дагуу актласан байгаа. НББОУС-ын дагуу хуримтлагдсан ашгийн данс руу нэмэгдсэн өртгийн бичилт хийж хаасан. Мөн 2010-2014 оны татварын

маргаантай холбоотой аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын акт тавигдсан байгаа. Үүнийг холбогдох стандартынхаа дагуу бичилт хийж хуримтлагдсан ашгийн данс руу урьд оны үр дүн рүү хаасан байгаа.

Богино хугацаат өр яагаад нэмэгдсэн бэ гэвэл дээрх татварын маргаантай холбоотой төлөх 533 сая төгрөгийн акт, татварын өр нэмэгдсэн байгаа.

Бусад зардлын гэж 586 сая төгрөгөө асууж байна уу?

**Д.Бейбит, хувьцаа эзэмшигч:** Тийм, тэгээд бусад ашиг алдагдлын дүнгээ бас тусад нь бичсэн байна.

**Л.Болдбаатар, МЦХ ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн албаны дарга:** Бусад ашиг гэж бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз бүртгэгдсэн байгаа. Аудитын зөвлөмжийн дагуу 26,550 мянган төгрөг бүртгэсэн. Бусад зардал гэсэн 586 сая төгрөг дээр банкны шимтгэл, ахмадын зардал, төвлөрсөн арга хэмжээ, ажилчдад холбоотой тэтгэмж урамшууллууд бүртгэгдсэн байгаа.

**М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал:** Богино хугацаат өр төлбөрт хариуцлагагүй зүйл бас байсан. 2016 оны 11 сард намайг энэ ажлыг авахад, урьдах удирдлагууд татвар, татвартай холбоотой маргааныг зөв зүйтэй авч үзээгүй, акт тавигдангуут нь Татварын ерөнхий газар, түүний татварын маргаан эцэслэдэг комисст асуудлаа тавилгүй маш хариуцлагагүй явснаас 900 гаруй төгрөгийн татварын өр төлбөрийн акт тавигдсан байсан. Маргаагүй, тэгээд хэрэг хөөн хэлэлцэх хугацаа нь өнгөрсөн. Үүнийг бид ТЕГ болон холбогдох байгууллагуудад тавьж, хасч болох боломжтойг нь хасч, дараа нь шүүхдэж явж НӨАТ болон зарим давхардсан татварыг бууруулж байж тэрбум гаргүй төгрөгийн татварыг 530 сая төгрөг болгож бууруулсан. Улс хоорондын ярианы орлогоос орж ирсэн орлогыг бүртгэхдээ бүртгэлийн асуудал үүссэн. Гадаадын компани Монголд үйл ажиллагаа явуулж байгаа мэтээр ойлгоод Оюутолгой, Рио Тинто шиг аж ахуйн онцгой албан татвар 20 хувиар тавьсан, бас бичилттэй холбоотой асуудлууд байгаа.

3.7 тэрбумын хуримтлагдсан ашиг бол 2004-2005 оноос ашигласан утасгүй My phone 5015-тай дугаартай үйлчилгээг 2012 онд ХХЗХ-ноос татан буулгасан. Түүний станц, тоног төхөөрөмж бараа материалыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргаж акталсан. Түүнтэй холбоотой зүйлүүд байгаа.

**Ц.Хуяг, хувьцаа эзэмшигч:** Төрийн зүгээс компанийн хувьчлалын тухай тодорхой барьж байгаа бодлого байгаа юу. Төрийн хувь бараг 95 хувь байх шиг байна. ТӨБЗГ-аас хувьчлалын талаар барьж байгаа бодлогыг танилцуулаач.

**А.Дагвадорж, Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:** Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Дэд дарга Дагвадорж байна. Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн тодорхой хувийг Корей телеком компанид хувьчлаад өнгөрсөн онд яаж шийдэгдсэнийг та бүхэн харж байгаа. Монголын төр буцаагаад авсан. ТӨБЗГ-аас төрийн өмчит компаниудын хувьчлал, менежментийн оновчлолтой нилээн өөр өөр байр суурьтай хандаж байгаа. Ялангуяа салбар салбарын хувьд. Дээр нь олон улсын жишиг

бол өөрөө аль болохоор л хувьчлах үйл явцыг хурдасгах, аль болох хувьчлалыг дэмжих бодлогыг барьж ажилласнаар ер нь төрийн өмчит компаниудын ашиг алдагдал, төрд, улс орны эдийн засагт, цааш цаашдаа ард түмэнд үзүүлэх нөлөөлөл нь ашигтай тусаж байгаа.

1997 оноос хойш хувьчлалын бодлогын баримт бичгийг 5 удаа УИХ-аас батлан гарсан байна. Хамгийн сүүлд 2015 онд ТӨК-уудын хувьчлалын жагсаалт УИХ-ын тогтоолоор батлагдсан. Түүнээс хойш тогтоолын төсөл дээр нэг ч өөрчлөлт оруулж чадаагүй явж байна. Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт 2, 3 ч удаа томоохон хэмжээний, тухайн яам тамгын газраас нь санал авч, төрийн өмчит компаниуд дээр хувьчлалын хэлбэр болон хувьчлалын саналаа хүргүүлсэн байгаа. Та бүхэн мэдэж байгаа, цэнхэр, ягаан тасалбар, түүний дараа хэд хэдэн удаагийн томоохон хувьчлалуудыг хийсэн байгаа. ЗГХЭГ-ын даргын тушаалаар эдгээрийн үр дүнг тооцохоор ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Үнэхээр салбараар нь яаж хуваах, хувьчлуул яаж хувьчлах талаар 5 сарын сүүлээр ажлын хэсгийн дүгнэлт гарна. Цахилгаан холбоо гэлтгүй бусад томоохон төрийн өмчит компаниудын хувьчлалын асуудлаар нилээн томоохон бодлогын шийдвэр УИХ-аар орж, гарах байх гэж найдаж байна.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьд бол яалт ч үгүй ногдол ашиг бол чухал. ТӨБЗГ-аас хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийг ашигтай ажиллуулах тал дээр шахаж ажиллаж байгаа. Ерөнхийдөө ногдол ашгийг аль болох их хуваарилахын тулд бодлогоор ажиллаж байгаа. МЦХ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдсэн байна. Энэ нь эдийн засаг, компанийн өөрчлөлт, бодлогын шинжтэй томоохон асуудалтай холбоотой шийдэгдсэн асуудал байна.

МЦХ ХК-ийн 2018 гүйцэтгэл, эдийн засгийн, санхүүгийн бүх гүйцэтгэлүүд ТӨБЗГ-ын ажлын хэсгээр орсон. Ер нь боломжийн гүйцэтгэлтэй гарсан гэж үзэж байгаа. Гэхдээ үндсэн үйл ажиллагааны орлогыг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай. Өнөөдөр энд танилцуулж байгаа технологийн шийдлийн хувьд тусгай зөвшөөрлийг ХХЗХ-ноос авсан байна. Энэ бол технологийн хувьд шийдэл, цаашлаад компанийн эдийн засгийн үзүүлэлтээр маш томоохон өөрчлөлт гэж харж байгаа. Энэ хүрээнд бид 2019 оны бизнес төлөвлөгөөний зорилтыг нь баталсан. Энэ технологийн шийдлээр шийдэж чадсан, буцаад компанийн ашгаа нэмэгдүүлэх байх гэсэн эдийн засгийн хүлээлттэй байгаа, тэрийгээ хангаж ажиллана. МЦХ ХК бол монголын томоохон ууган компаниудын нэг. Одоо байгаа суурь бүтэц, шинэчлэлээрээ Улаанбаатар хот, аймаг, бүх сумдад суурин утасны хэрэглээг бодлогын хувьд барьж байгаа ганц компани. Суурин утасны хамгийн том хэрэглэгч төрийн хэрэглэгч нарыг хамгийн түрүүнд шинэлэг технологидоо шилжүүлж, МЦХ-иар хүргүүлэх талаар төр өөрөө менежментээ хийх шаардлагатай. Энэ талаар компанийн удирдлагууд идэвх санаачлагатай ажиллах ёстой. Үүнийг ч ТӨБЗГ-аас дэмжиж ажиллана. Аль болох Хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хөндсөн, ашиг хуваарилах талаар шахаж ажиллаж байгаа.

**Ц.Хуяг, хувьцаа эзэмшигч:** Нэгж хэрэглэгчийн орлого 15 хувиар өссөн гэсэн. Тайлангаа харахаар нийт орлого унасан байгаа. Суурин хэрэглэгчдийн тоо унаж байна, ойролцоогоор 20 хувиар унаж байгаа юм уу. Энд үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж байгаа хэрэглэгч, харилцагч маань хэдэн хувиар буурсан байна. Цаашдаа ч

гэсэн буурах хандлагатай байгаа бол 2019 оны орлогын төлөвлөгөө ч гэсэн нилээд доогуур гарах болов уу гэсэн хувийн таамаг байна. Энэ дээр тайлбар хэлээч.

**Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга:** Дүгнэлт ерөнхийдөө зөв л өө. Суурин утасны хэрэглэгчийн төлөвлөгөөний биелэлт 95.8 хувьтай, өнгөрсөн онд жишээ нь 1990 хэрэглэгч шинээр холбоод, буцаад 4303 хэрэглэгч цуцлагдсан байгаа. Цэвэр үзүүлэлтээрээ хэрэглэгчийн тоо буурсан. Нөгөө талдаа нэгж хэрэглэгчээс орох орлого нэмэгдэж байгаа. Хувь хэрэглэгч дээр суурин утасны хэрэглээ багассан, гар утастай болсон учраас гэрийн утас хэрэглэхгүй болсон. Энэ нь хэдэн жилийн өмнөөс тасралтгүй гарч байгаа тенденц байгаад байна. Алба хэрэглэгч нар суурин утсыг албаны хэрэгцээгээр зайлшгүй хэрэглэх шаардлагатай, албан байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны тогтвортой байдлыг илэрхийлдэг үзүүлэлт болоод байгаа. Тэр талаасаа албан байгууллагын хэрэглэгч цуцлалт бага байдаг, нөгөө талаар хэрэглээ нилээн өндөр байдагтай холбоотой ийм үзүүлэлт гарсан.

**Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч:** Захирлын тайлан компанийн үйл ажиллагаа, өнөөдрийн байдлыг тов тодорхой харуулсан, цаашдынхаа зорилтыг тодорхойлсон илтгэл боллоо гэж үзэж байна. Тус компанийн хувьд сүүлийн 2 жилд компанийн үр өгөөжийг дээшлүүлэх, технологийг тууштай нэвтрүүлэх, цаашдын компанийн хөгжлийн ирээдүйн суурийг тавихад чухал, чухал арга хэмжээнүүдийг авч явуулж байгаа гэж ойлгож байна. Энэ ч үндсэн дээр компанийг тодорхой хэмжээний орлого, нэг цэгээс олох орлого нэмэгдэх, ашгийг төлөвлөгөө нэмэгдэх зэрэг хандлага гарч байгаа юм. Хэдийгээр орлогын төлөвлөгөө тасарсан боловч, зардлаа хэмнээд өнгөрсөн онд тавьсан ашгаа 4 дахин биелүүлсэн амжилттай байна. Тэр тоон үзүүлэлтүүд өссөн үзүүлэлтүүд байна л даа, тэдгээр нь тодорхой шалтгаантай, миний хувьд бол, сүүлийн жилүүдэд энэ компанийн үйл ажиллагаа ихээхэн доголдож, ер нь тавигдсан хүн бол компанийн цаашдын үйл ажиллагааг анхаардаггүй, өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хандаж, ажиллаж ирсэн тул компанийн өмнө тулгарсан зорилт маш их байсан. Сүүлийн хоёр жил энэ баасыг арилгахад компани тууштай ажиллаж байгаа гэж бодож байгаа. Сая ч гэсэн тэр өр авлага дээр түүнийг багасгаж, хамгийн эцсийн цэгт нь хүрсний үндсэн дээр шүүхийн шийвэр гаргаж байгаа юм шиг харагдаж байна.

Компанийн цаашдын үйл ажиллагаанд шинэ технологи тууштай нэвтрүүлэх шаардлагатай.

Оны эхээр тоон системийн станцаа дөнгөж солиод хэдхэн хонож байхад 3 дахь үеийн буюу Soft Switch-ийн дараагийн технологийн асуудал яригдаж байна. Тэгэхээр мэдээлэл, холбооны технологи өндөр хурдтай хөгжиж байгаа нь харагдаж байна. Энэ чиглэлээр тодорхой асуудлыг ирэх оны төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодорхой тусгасан байна.

Компанийн үйл ажиллагааны талаар хамт олон нилээн тууштай цаашид хөгжих ирээдүйтэй алсыг харсан бодлого явуулж байгаа нь үр дүнд хүрэх байх гэж найдаж байна. Компанийн удирдлага, хамт олонд жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс талархсанаа илэрхийлж байна.

Дээр нь нэмж хэлэхэд манай компани /би манай гэж ярья, хувьцаа эзэмшигчийн хувьд буруудахгүй байх/ бол үйл ажиллагаа нь их сонин, монголд ийм компани байхгүй байх.

Мэдээлэл холбооны сүлжээ компанийн мэдэлд, үйл ажиллагаа нь тэдний аясыг дагаж явдаг. Яагаад гэвэл 2007 онд манай засаг төрийн удирдлагын гэх юм уу тэр үед байсан хүмүүсүүдийн алдаатай бодлого гэж ойлгодог. Массын сүлжээг нь дундуур нь таслаад МХС компанийн өмч болгоод байгуулсан. Хоёр талынх нь юм тус компанид байдаг. Тэгэхээр үйл ажиллагаа явуулахаар энд станц байдаг, тэнд хэрэглээ байдаг. Тэнд хүргэхийн тулд МХС компаниас дамжуулах сүлжээг нь гуйж энэ болох уу үгүй юу гэсэн хараат байдалд 12 жил ажилласан. Сүүлийн үед 2016 оноос энэнээс гарахын тулд GPON технологийг нэвтрүүлж, МХС-ийн дамжуулах сүлжээний ихэнх хэсгийг нь алгасаж өөрийн сүлжээг байгуулсан ийм ажилд ороод явж байна. Үүний тул энэ ажлыг хэрэгжүүлэхэд манай том хувьцаа эзэмшигч хүчин чармайлт гаргаж, дэмжиж тусалдгийг ойлгож байна. Цаашдаа ч гэсэн МХС компанийн трансмисси системийг яах юм бэ гэдэг хоорондын уялдааг зохицуулах талаар дэмжлэг үзүүлж, бодитой арга хэмжээг авч ажиллана гэдэгт найдаж байна.

Эцэст нь нэг асуудал байна. Манай компанийн хувьд төрийн өмчийн оролцоотой, нээлттэй компани гэж компанийнхаа дүрэмд байж байдаг. Компанийн тухай хуулийн 2.4-д “Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэсэн байна. Яагаад хэлээд байна вэ гэвэл бодит амьдралд компанийн дүрмийнхээ хүрээнд шийдэх асуудалд Төрийн өмчийн хуулиар зохицуулах тухай юм явагдаад байх шиг санагддаг, би бас буруу харж байж магадгүй. Зарим нэг үйл ажиллагаа асуудлыг заавал энд шийдсэнийг дахин шийдээд байх шиг байна. Энэ Төрийн өмчийн тухай хуулиар уу эсвэл компанийн тухай хуулиар зохицуулах юм уу гэдгийг нэг талд нь гаргаж өгвөл энэ компани үйл ажиллагаагаа түргэн шуурхай шийдэхэд нь нөлөөлөх юм болов уу гэсэн нэг санал байна.

**А.Дагвадорж, Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:** Тийм зүйл бий, ойлгож байгаа. Ерөнхийдөө Цахилгаан холбоо компани дээр ч биш. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Компанийн тухай хуулийн зарим нэг ижил төстэй заалтууд нь зарим нэг компани дээр өөр байгаад байгаа. Мэдээлэл өгөхөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагааг хуульчлан оруулж байгаа. Хууль маань энэ намрын чуулганаар орно. Нилээн том өөрчлөлт орж байгаа. Энэ дээр энэ хоёр хуулийн асуудлыг цэгцэлж байгаа. Нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хуулиар явна. Намрын чуулганаар орон хуулиар хуулийн давхардаад байгаа зүйл, эрхзүйн зохицуулалт нилээн сайн хийгдэх байх гэж бодож байгаа.

**Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга:** Асуулт хариулт, саналын хэсгийг дуусгаж, санал хураалт явуулж, хурлыг түр завсарлуулав.

**Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга:** Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

### Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 25,870,276 ширхэг хувьцаа буюу 3,955 хувьцаа эзэмшигчдээс 25,047,858 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 20 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 20 саналын хуудас хүчинтэй, хүчингүй саналын хуудас гарсангүй.

Саналын хуудсанд 4 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр дараах санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай  
Зөвшөөрсөн 19 санал буюу 97.83 хувь 24,505,401 ширхэг хувьцаа  
Татгалзсан 1 санал буюу 2.16 хувь 542,456 ширхэг хувьцаа  
Түдгэлзсэн байхгүй
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай  
Зөвшөөрсөн 19 санал буюу 97.83 хувь 24,505,401 ширхэг хувьцаа  
Татгалзсан 1 санал буюу 2.16 хувь 542,456 ширхэг хувьцаа  
Түдгэлзсэн байхгүй
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай  
Зөвшөөрсөн 19 санал буюу 97.83 хувь 24,505,401 ширхэг хувьцаа  
Татгалзсан 1 санал буюу 2.16 хувь 542,456 ширхэг хувьцаа  
Түдгэлзсэн байхгүй
4. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай  
Зөвшөөрсөн 19 санал буюу 99.99 хувь 25,047,658 ширхэг хувьцаа  
Татгалзсан 1 санал буюу 0.00079 хувь 199 ширхэг хувьцаа  
Түдгэлзсэн байхгүй

### ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
    - Нийт хөрөнгийг 40,876,412,194.13 (дөчин тэрбум найман зуун далан зургаан сая дөрвөн зуун арван хоёр мянга нэг зуун ерэн дөрвөн төгрөг арван гурван мөнгө) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 26,698,568,709.51 (хорин

зургаан тэрбум зургаан зуун ерэн найман сая таван зуун жаран найман мянга долоон зуун есөн төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөг;

- Өр төлбөрийн нийт дүнг 7,210,177,824.42 (долоон тэрбум хоёр зуун арван сая нэг зуун далан долоон мянга найман зуун хорин дөрвөн төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөг;
  - Эзэмшигчийн өмчийг 33,666,234,369.71 (гучин гурван тэрбум зургаан зуун жаран зургаан сая хоёр зуун гучин дөрвөн мянга гурван зуун жаран есөн төгрөг далан нэгэн мөнгө) төгрөг.
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг батлав.
4. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 99.99 хувийн саналаар батлав.
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг Хавсралт ёсоор батлав.
- Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

Танилцсан:



Ч.Пүрэвсүрэн, 2019 оны Хувьцаа  
эзэмшигчдийн ээлжит хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:



Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

2019 оны 4 дүгээр сарын 30  
Улаанбаатар хот.